

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ахмад настны үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/010/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 261628 Цахим хаяг: tsogbayar.a@audit.gov.mn
Аудитор: Г.Өсөхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: usukhjargal.g@audit.gov.mn Си Эс
Ай Аудит ХХК-ийн захирал:
Утас: 99096584 Цахим хаяг: sevjidmaa@csiaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/720
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр нь туслах мал аж ахуйн хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 32,668.0 мянган төгрөгөөр эх үүсвэрийг бүрдүүлж, багаж техник хэрэгслийн зардалд 29,725.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,943.0 мянган төгрөг нийт 32,668.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөхдөө асрамжийн байрны хүчин чадлаар буюу 250 үйлчлүүлэгчээр тооцож, 380,163.2 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч тайлант оны дунджаар тэтгэвэр авагч ахмад настан 126 хүн, халамжийн тэтгэвэр авагч

ахмад настан 55 хүн, нийт 181 үйлчлүүлэгчийн тэтгэвэр, тэтгэмжийн орлогын 30 хувь буюу 317,697.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн асрамж нь хүчин чадлаар ажиллаагүйгээс орлогын төлөвлөгөө 62,466.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Ахмад настны үндэсний төвийн 100 жилийн ойн арга хэмжээг Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/49 тоот тушаалаар Улсын ууган асрамжийн газар болох тус яамны харьяа Ахмад настны үндэсний төв үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг 2024 оны 5 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрч ойн арга хэмжээг хийсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	505,746,247.34	1,174,224,317.44
33	АВЛАГА	28,628,081.70	35,165,594.17
33300	Татаас, санхүүжилтийн авлага		33,719,814.10
33402	Татвар, НДШ - ийн авлага /ТӨҮГ/		1,445,780.07
335	Бусад авлага	28,628,081.70	
3351	Байгууллагаас авах авлага	28,628,081.70	
34	УРЬДЧИЛГАА	-	
35	БАРАА МАТЕРИАЛ	477,118,165.64	1,139,058,723.27
351	Түүхий эд материал	31,012,150.20	79,788,188.63
35130	Эм боох материал	31,012,150.20	79,788,188.63
354	Хангамжийн материал	365,166,015.44	1,013,420,534.64
35410	Бичиг хэргийн материал	685,900.00	1,127,000.00
35420	Аж ахуйн материал	125,011,782.00	208,672,898.00
35440	Түлш, шатах тослох материал	9,537,320.00	23,103,889.64
35460	Хүнсний материал	51,328,767.04	23,103,889.64
35470	Бусад хангамжийн материал	178,602,246.40	23,103,889.64
35600	Мал амьтад	80,940,000.00	23,103,889.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,048,089,709.07	10,395,740,289.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,048,089,709.07	9,910,740,289.77
392	Биет хөрөнгө	9,643,388,329.07	9,992,798,909.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,436,405,448.08	10,921,405,448.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,453,711,367.62)	(1,650,799,564.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	291,918,764.00	311,418,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(233,033,347.36)	(248,479,180.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,343,461,008.44	1,384,242,308.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(793,612,943.27)	(778,356,093.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,126,680.00	186,186,879.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(115,165,913.20)	(132,819,651.78)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	
393	Биет бус хөрөнгө	404,701,380.00	402,941,379.96
39301	Программ хангамж	9,570,000.00	9,570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(2,530,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	395,901,380.00	395,901,380.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,553,835,956.41	11,569,964,607.21
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	-	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	
413	Өглөг	-	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,553,835,956.41	11,569,964,607.21
51	Засгийн газрын хувь оролцоо	10,553,835,956.41	11,569,964,607.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,264,908,232.00	1,264,908,232.00
51101	Өмч:- төрийн	1,264,908,232.00	1,264,908,232.00
512	Хуримтлагдсан үр дүн	8,484,001,885.37	9,500,130,536.17
51210	Өмнөх үеийн үр дүн	8,815,044,882.48	8,484,001,885.37
51220	Тайлант үеийн үр дүн	(331,042,997.11)	1,016,128,650.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	804,925,839.04	804,925,839.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,553,835,956.41	11,569,964,607.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,053,271,701.20	6,985,456,835.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	481,676,401.20	984,631,435.94
120	Нийтлэг татварын бус орлого	481,676,401.20	984,631,435.94
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	481,046,401.20	418,557,565.94
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	317,697,041.20	385,889,565.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		32,668,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	163,349,360.00	
120009	Бусад орлого	630,000.00	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		495,272,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		70,801,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,571,595,300.00	6,000,825,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,504,020,300.00	6,000,020,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,504,020,300.00	6,000,020,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,575,000.00	805,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	67,575,000.00	805,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,384,314,698.31	5,968,310,218.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,384,314,698.31	5,968,310,218.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,209,883,312.27	5,866,864,281.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,871,961,793.47	3,258,888,686.90
210101	Үндсэн цалин	1,101,963,868.40	1,552,137,567.49
210102	Нэмэгдэл	536,790,581.05	1,454,137,304.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,061,446.56	55,552,439.20
210104	Урамшуулал	175,145,897.46	197,061,375.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	236,353,298.19	410,054,937.51
210201	Тэтгэврийн даатгал	166,942,593.47	285,486,953.28
210202	Тэтгэмжийн даатгал	18,536,633.97	32,729,062.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,543,800.00	17,873,685.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,278,301.34	15,397,103.15
210205	Эрүүл мэндийн даатгал	33,051,969.41	58,568,132.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	343,160,645.82	406,996,582.79
210301	Гэрэл, цахилгаан	130,445,665.83	128,895,942.79
210302	Түлш, халаалт	196,921,879.99	258,361,640.00
210303	Цэвэр, бохир ус	15,793,100.00	19,739,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	146,650,487.30	124,147,871.22
210401	Бичиг хэрэг	2,663,350.00	5,171,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,443,000.00	21,446,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,074,002.01	2,584,187.22

Ахмад настны үндэсний төвий 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000.00	183,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	101,905,135.29	4,095,400.00
210408	Бараа материал акталсны зардал	15,065,000.00	75,093,669.00
2105	Нормативт зардал	930,366,180.64	1,100,743,059.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,983,097.26	128,498,041.57
210502	Хоол, хүнс	709,405,095.18	780,645,771.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	117,977,988.20	191,599,247.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195,663,842.00	188,385,525.00
210604	Урсгал засвар	195,663,842.00	188,385,525.00
2107	Томилолт, зочны зардал	-	
210702	Дотоод албан томилолт	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,068,018.00	71,835,165.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,339,799.00	61,186,526.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,000.00	549,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,596,599.00	467,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,116,000.00	1,099,000.00
210807	Газрын төлбөр	2,966,620.00	3,532,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	392,659,046.85	305,812,452.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,260,000.00	68,720,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	350,399,046.85	237,092,452.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174,431,386.04	101,445,936.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,078,500.00	69,757,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,778,500.00	38,979,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		28,437,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,352,886.04	31,688,836.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,352,886.04	31,688,836.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(331,042,997.11)</u>	<u>1,017,146,617.52</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,017,966.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(1,017,966.72)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(331,042,997.11)</u>	<u>1,016,128,650.80</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,933,137,741.20	6,419,382,965.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	361,542,441.20	418,557,565.94
120	Нийтлэг татварын бус орлого	361,542,441.20	418,557,565.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	317,697,041.20	418,557,565.94
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	317,697,041.20	385,889,565.94
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	32,668,000.00
120009	Бусад орлого	43,845,400.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,571,595,300.00	6,000,825,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,504,020,300.00	6,000,020,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,504,020,300.00	6,000,020,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,575,000.00	805,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	67,575,000.00	805,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,873,482,691.20	6,341,406,965.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,873,482,691.20	6,341,406,965.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,699,051,305.16	6,206,241,214.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,872,942,695.96	3,260,334,466.97
210101	Үндсэн цалин	1,101,947,069.36	1,539,138,509.15
210102	Нэмэгдэл	537,785,846.67	1,467,136,363.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,063,882.47	61,135,639.20
210104	Урамшуулал	175,145,897.46	192,923,955.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,739,237.36	410,054,937.51
210201	Тэтгэврийн даатгал	166,328,532.64	279,216,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,536,633.97	32,729,062.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,543,800.00	17,873,685.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,249,941.34	15,397,103.15
210205	Эрүүл мэндийн даатгал	33,080,329.41	64,838,485.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	346,719,965.83	418,469,602.43
210301	Гэрэл, цахилгаан	130,445,665.83	128,895,942.79
210302	Түлш, халаалт	200,796,400.00	269,834,659.64
210303	Цэвэр, бохир ус	15,477,900.00	19,739,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,227,164.01	93,044,087.22
210401	Бичиг хэрэг	1,048,900.00	2,784,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,482,200.00	23,540,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,075,402.01	2,584,187.22
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,087,400.00	4,095,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,533,262.00	60,040,400.00
2105	Нормативт зардал	883,864,100.00	1,668,544,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,334,200.00	172,103,120.00

Ахмад настны үндэсний төвий 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

210502	Хоол, хүнс	667,529,900.00	1,137,409,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000,000.00	359,031,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,403,500.00	22,243,710.00
210604	Урсгал засвар	7,403,500.00	22,243,710.00
2107	Томилолт, зочны зардал	-	
210702	Дотоод албан томилолт	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	291,154,642.00	333,550,390.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	280,426,423.00	322,901,751.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,000.00	549,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,502,750.00	467,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,116,000.00	1,099,000.00
210807	Газрын төлбөр	3,060,469.00	3,532,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174,431,386.04	135,165,750.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,078,500.00	69,757,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,778,500.00	38,979,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		28,437,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,352,886.04	65,408,650.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,352,886.04	65,408,650.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>59,655,050.00</u>	<u>77,976,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	59,655,050.00	77,976,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,655,050.00	77,976,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,655,050.00	77,976,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,655,050.00	77,976,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(59,655,050.00)</u>	<u>(77,976,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,966,224,996.54	11,036,059,067.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,815,044,882.48	10,884,878,953.52
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(331,042,997.11)	(331,042,997.11)
8	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,484,001,885.37	10,553,835,956.41
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,484,001,885.37	10,553,835,956.41
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	1,016,128,650.80	1,016,128,650.80
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,500,130,536.17	11,569,964,607.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,390,183,600.00	6,320,501,314.97	69,682,285.03	98.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,390,183,600.00	6,320,501,314.97	69,682,285.03	98.9
УРСГАЛ ЗАРДАЛ	6,320,421,300.00	6,250,744,214.97	69,677,085.03	98.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,284,908,900.00	3,260,334,466.97	24,574,433.03	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,390,183,600.00	6,320,501,314.97	69,682,285.03	98.9
Үндсэн цалин	1,551,400,400.00	1,539,138,509.15	12,261,890.85	99.2
Нэмэгдэл	1,458,118,700.00	1,467,136,363.06	(9,017,663.06)	100.6
Унаа хоолны хөнгөлөлт	90,450,200.00	61,135,639.20	29,314,560.80	67.6
Урамшуулал	184,939,600.00	192,923,955.56	(7,984,355.56)	104.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	410,613,600.00	410,054,937.51	558,662.49	99.9
Тэтгэврийн даатгал	279,217,300.00	279,216,600.00	700.00	100.0
Тэтгэмжийн даатгал	32,849,100.00	32,729,062.57	120,037.43	99.6
ҮОМШӨ-ний даатгал	16,424,500.00	17,873,685.80	(1,449,185.80)	108.8
Ажилгүйдлийн даатгал	16,424,600.00	15,397,103.15	1,027,496.85	93.7
Эрүүл мэндийн даатгал	65,698,100.00	64,838,485.99	859,614.01	98.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	419,778,400.00	418,469,602.43	1,308,797.57	99.7
Гэрэл, цахилгаан	136,808,200.00	128,895,942.79	7,912,257.21	94.2
Түлш, халаалт	263,230,700.00	269,834,659.64	(6,603,959.64)	102.5
Цэвэр, бохир ус	19,739,500.00	19,739,000.00	500.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	97,250,600.00	97,244,087.22	6,512.78	100.0
Бичиг хэрэг	1,981,000.00	1,979,100.00	1,900.00	99.9
Тээвэр, шатахуун	23,544,000.00	23,540,000.00	4,000.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,200.00	2,584,187.22	(53,987.22)	102.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,095,400.00	4,095,400.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,100,000.00	65,045,400.00	54,600.00	99.9
Нормативт зардал	1,675,372,400.00	1,671,044,020.00	4,328,380.00	99.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174,611,800.00	174,603,120.00	8,680.00	100.0
Хоол, хүнс	1,141,100,000.00	1,137,409,400.00	3,690,600.00	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	359,660,600.00	359,031,500.00	629,100.00	99.8
Эд хогшил, урсгал засварын зардал	30,864,700.00	30,778,710.00	85,990.00	99.7
Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,988,000.00	12,000.00	99.9
Урсгал засвар	20,864,700.00	20,790,710.00	73,990.00	99.6
Томилолт, зочны зардал	82,900.00	0.00	82,900.00	0.0
Дотоод албан томилолт	82,900.00	0.00	82,900.00	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	401,549,800.00	362,818,390.84	38,731,409.16	90.4

Ахмад настны үндэсний төвий 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,163,200.00	352,169,751.84	37,993,448.16	90.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	5,000,000.00	500,000.00	90.9
Даатгалын үйлчилгээ	549,000.00	549,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	468,000.00	467,920.00	80.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,099,300.00	1,099,000.00	300.00	100.0
Газрын төлбөр	3,770,300.00	3,532,719.00	237,581.00	93.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,762,300.00	69,757,100.00	5,200.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	69,762,300.00	69,757,100.00	5,200.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,979,600.00	38,979,600.00	0.00	100.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,437,500.00	28,437,500.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,345,200.00	2,340,000.00	5,200.00	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,390,183,600.00	6,385,909,965.94	4,273,634.06	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,000,020,400.00	6,000,020,400.00	0.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	6,000,020,400.00	6,000,020,400.00	0.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	390,163,200.00	385,889,565.94	4,273,634.06	98.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	390,163,200.00	385,889,565.94	4,273,634.06	98.9
АЖИЛЛАГСДЫН ТОО	123.00	112.00	11.00	91.1
Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	42.00	31.00	11.00	73.8
Үйлчлэх ажилтан	80.00	80.00	0.00	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		32,668,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		32,668,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		32,668,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		32,668,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		29,725,000.00
210604	Урсгал засвар		2,943,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		32,668,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		32,668,000.00
131105	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		32,668,000.00

Ахмад настны үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

3. АУДИТЫН ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ:

Аудитаар нийт 677.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 624.3 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 52.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 624.3 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 624.3 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын дансанд 12,513.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн.	1	12,513.0			1	12,513.0	1	12,513.0				
НДШ-ийн өглөгийн дансанд цалингаас суутгасан 29,628.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бичсэн байна.	1	29,628.0			1	29,628.0	1	29,628.0				
Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн цалингийн дүнг мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 47,335.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	47,335.7			1	47,335.7	1	47,335.7				

Ахмад настны үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

Цалин хөлсний программд 2024 оны 5 дугаар сард 39 ажилтны ажилласан цагийг дутуу оруулснаас 16,135.5 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон нь цалин хөлсний тооцоололд тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.	1	16,135.5	1	16,135.5			1	16,135.5				
Үндсэн үйл ажиллагааны орлогод төвлөрүүлсэн 33,719.8 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй буцаан төвлөрүүлэх шилжүүлэг гэж үйл ажиллагааны зардалд бичилт хийсэн.	1	33,719.8	1	33,719.8			1	33,719.8				
Монгол улсын хүн ам хөгжил нийгэм хамгааллын яам нь Ахмад настны үндэсний төвийн барилгын дээврийн засварын ажил гүйцэтгүүлэх 485,000.0 мянган төгрөгийн засварыг үнэ төлбөргүй хийж гүйцэтгэсэн бөгөөд асрамжийн барилгын дээврийн ажлыг Интел Хаймек компани гүйцэтгэж 2024 оны 12 дугаар сарын 13-нд улсын комисст хүлээлгэн өгснийг данс бүртгэлд бүртгээгүй байсныг залруулж барилга капиталжуулж бүртгэсэн	1	485,000.0	1	485,000.0			1	485,000.0				
Дүн	6	624,332.0	3	534,855.3	3	89,476.7	6	624,332.0				

Ахмад настны үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан

3.2.Аудитаар нийт 53.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 52.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус төвийн цалин хөлсийг нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад нийт 5 ажилтны НДШ-ийн 1,445.8 мянган төгрөгийг илүү төлсөн.	1	1,445.8					1	1,445.8				
Тайлант онд зардлын ангиллыг 50,774.2 мянган төгрөгөөр зориулалт бусаар тайлагнасан. Үүнд: үндэсний баяр наадам, эмэгтэйчүүдийн баяр, олон улсын ахмадын өдөр, шинэ жилийн арга хэмжээнд зориулж хэрэглэсэн 50,774.2 мянган төгрөгийн зардлыг үйлчлүүлэгчдийн хоолны зардалд тайлагнасан.	1	50,774.3					1	50,774.3				
Асрамж нэгдүгээр байрны нэг ээлжийн 4 сувилагчийн 1-12 сарын илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон тооцооллыг давтан шалгахад 48 цагийн хөлс 901.1 мянган төгрөгийг илүү олгосон.	1	901.2	1	901.2								
Дүн	3	53,121.2	1	901.2			2	52,220.0				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 54 ахмад настантай боловч нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлээгүй байна.	1	-		-	1	-
Дүн	1	-			1	